УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/015/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Авирмэд<br>Утас: 70453317, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.5.1 Төсвийн төлөвлөлт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

3.5.3 Нэмэлт төсөв

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

4.1 Ерөнхий зүйл

4.2 Материаллаг байдал

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.12 № ОВА-2026/15/НА-СТА-ТЦ3

танай______________-ны №__________________-т

УВС АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ДОРЖГОТОВ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

8575050189

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,335,882,635.42** | **4,661,542,024.33** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 838,390,562.58 | 1,120,669,927.97 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 838,390,562.58 | 1,120,669,927.97 |
| **3121** | **Төгрөг** | 838,390,562.58 | 1,120,669,927.97 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 838,390,562.58 | 1,120,669,927.97 |
| **33** | **АВЛАГА** | 2,131,882,373.53 | 2,327,998,872.77 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,333,826.57 | 2,675,516.44 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 2,123,654,846.96 | 2,318,429,656.33 |
| **335** | **Бусад авлага** | 6,893,700.00 | 6,893,700.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,409,000.00 | 5,409,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,484,700.00 | 1,484,700.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,365,609,699.31 | 1,212,873,223.59 |
| **351** | **Түүхий эд материал** | 950,594,086.47 | 824,261,456.06 |
| 35130 | Эм боох материал | 950,594,086.47 | 824,261,456.06 |
| **354** | **Хангамжийн материал** | 415,015,612.84 | 388,611,767.53 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,465,950.00 | 6,969,740.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 18,225,886.00 | 18,018,250.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 31,899,095.00 | 12,198,785.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 7,006,450.00 | 9,265,950.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,430,527.06 | 7,190,984.66 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 347,987,704.78 | 334,968,057.87 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **22,780,901,444.31** | **33,343,162,364.93** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 22,780,901,444.31 | 33,343,162,364.93 |
| **392** | **Биет хөрөнгө** | 22,145,821,444.31 | 32,708,082,364.93 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 16,331,299,718.81 | 16,425,071,326.52 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,070,572,995.70 | -1,408,919,498.14 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,730,733,089.23 | 1,741,614,839.23 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -749,139,691.03 | -879,021,072.34 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 14,805,448,802.20 | 26,321,828,987.18 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -9,348,073,504.95 | -10,627,065,643.87 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 732,364,288.27 | 1,279,673,120.89 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -409,113,342.80 | -467,886,034.11 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 303,744,777.68 | 553,261,523.96 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -181,533,897.40 | -231,139,384.39 |
| 39217 | Ном | 664,200.00 | 664,200.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 635,080,000.00 | 635,080,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,400,000.00 | -2,400,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 635,080,000.00 | 635,080,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **27,116,784,079.73** | **38,004,704,389.26** |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **892,528,953.67** | **306,561,758.70** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 892,528,953.67 | 306,561,758.70 |
| **413** | **Өглөг** | 444,158,953.67 | 204,616,458.70 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 11,564,225.99 | 2,962,112.83 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 408,644,007.68 | 198,677,544.87 |
| **4136** | **Бусад өглөг** | 23,950,720.00 | 2,976,801.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 23,950,720.00 | 782,500.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 2,194,301.00 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | 448,370,000.00 | 101,945,300.00 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 448,370,000.00 | 101,945,300.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **26,224,255,126.06** | **37,698,142,630.56** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 26,224,255,126.06 | 37,698,142,630.56 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,952,435,948.94 | 4,952,435,948.94 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,952,435,948.94 | 4,952,435,948.94 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 15,571,167,747.39 | 27,050,950,734.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 15,571,167,747.39 | 15,577,063,229.68 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 11,473,887,504.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 5,700,651,429.73 | 5,694,755,947.44 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **27,116,784,079.73** | **38,004,704,389.26** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **23,637,195,874.90** | **36,279,321,676.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,150,235,315.91** | **34,743,528,576.56** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,695,945,360.91 | 13,294,008,930.56 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,004,863,442.45 | 1,346,403,899.73 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 556,493,442.45 | 776,029,199.73 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 448,370,000.00 | 570,374,700.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 19,454,289,955.00 | 21,449,519,646.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 19,454,289,955.00 | 21,449,519,646.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,486,960,558.99** | **1,535,793,100.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,486,960,558.99 | 1,535,793,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,486,960,558.99 | 1,535,793,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **21,953,702,302.89** | **24,800,563,380.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,953,702,302.89** | **24,800,563,380.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 21,910,703,302.89 | 24,753,176,780.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 12,346,311,317.08 | 14,088,624,557.15 |
| 210101 | Үндсэн цалин | 7,929,507,340.46 | 8,069,538,856.98 |
| 210102 | Нэмэгдэл | 4,416,803,976.62 | 4,499,578,518.99 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 419,128,585.62 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 1,100,378,595.56 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,583,790,261.05 | 1,781,551,194.52 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,103,796,195.44 | 1,155,535,623.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 126,384,590.22 | 136,878,612.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 101,107,672.14 | 100,062,063.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 21,118,246.79 | 45,195,831.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 231,383,556.46 | 343,879,062.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,440,402,003.99 | 1,611,091,172.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 168,167,565.39 | 153,534,761.52 |
| 210302 | Түлш, халаалт | 957,004,710.60 | 1,122,838,448.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 315,229,728.00 | 334,717,963.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 356,474,521.72 | 328,114,122.15 |
| 210401 | Бичиг хэрэг | 25,961,460.00 | 27,012,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 173,681,010.00 | 124,411,027.69 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,828,669.05 | 31,068,076.47 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,706,360.00 | 14,309,774.27 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 103,326,921.67 | 80,614,973.72 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 29,970,101.00 | 50,698,020.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,205,467,145.53 | 4,643,035,343.61 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,879,795,184.83 | 4,314,818,850.21 |
| 210502 | Хоол, хүнс | 325,671,960.70 | 328,216,493.40 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 134,219,937.00 | 187,902,480.85 |
| 210604 | Урсгал засвар | 134,219,937.00 | 187,902,480.85 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 58,519,800.00 | 61,775,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 58,519,800.00 | 61,775,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 150,563,584.36 | 182,199,168.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 96,810,780.00 | 105,174,301.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,140,000.00 | 1,140,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,500,000.00 | 6,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 756,684.36 | 935,437.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 341,000.00 | 363,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 25,166,960.00 | 35,780,030.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,350,800.00 | 6,350,800.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 18,497,360.00 | 25,955,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,634,954,732.16 | 1,868,883,641.75 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,448,900.00 | 12,260,750.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,628,505,832.16 | 1,856,622,891.75 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 42,999,000.00 | 47,386,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 42,999,000.00 | 47,386,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 42,999,000.00 | 47,386,600.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,683,493,572.01** | **11,478,758,296.01** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 68142075.14 | 4870791.51 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 68,142,075.14 | 4,870,791.51 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,615,351,496.87** | **11,473,887,504.50** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **22,635,443,405.22** | **23,790,517,136.36** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **21,148,482,846.23** | **22,254,724,036.36** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,004,863,442.45 | 999,979,199.73 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,004,863,442.45 | 999,979,199.73 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 556,493,442.45 | 776,029,199.73 |
| **122** | **Тусламжийн орлого** | 20,143,619,403.78 | 21,254,744,836.63 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 20,143,619,403.78 | 21,254,744,836.63 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,486,960,558.99** | **1,535,793,100.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,486,960,558.99 | 1,535,793,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,486,960,558.99 | 1,535,793,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **21,814,674,332.57** | **23,508,237,770.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,814,674,332.57** | **23,508,237,770.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **21,769,334,832.57** | **23,462,761,170.97** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 12,711,611,812.48 | 14,136,462,495.91 |
| 210101 | Үндсэн цалин | 8,377,477,827.01 | 8,069,538,856.98 |
| 210102 | Нэмэгдэл | 3,997,147,613.51 | 4,547,416,457.75 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 249,147,085.96 | 419,128,585.62 |
| 210104 | Урамшуулал | 87,839,286.00 | 1,100,378,595.56 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,533,071,464.28 | 1,745,717,058.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,034,280,842.66 | 1,250,583,701.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 124,853,206.74 | 122,612,015.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 68,813,235.65 | 68,861,269.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 66,755,338.18 | 57,139,036.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 238,368,841.05 | 246,521,036.01 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,832,902,377.69 | 1,535,793,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 168,167,565.39 | 153,534,761.52 |
| 210302 | Түлш, халаалт | 1,349,505,084.30 | 1,047,544,375.48 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 315,229,728.00 | 334,713,963.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 279,746,313.72 | 329,543,558.69 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,454,216.00 | 22,611,880.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 121,469,495.00 | 131,393,187.69 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 17,359,032.72 | 33,412,231.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 13,539,000.00 | 8,528,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 107,924,570.00 | 133,597,860.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,424,965,654.59 | 4,779,177,841.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,076,077,934.09 | 4,424,451,490.80 |
| 210502 | Хоол, хүнс | 315,782,720.50 | 330,389,301.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 33,105,000.00 | 24,337,050.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 714,232,607.45 | 674,049,478.78 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 123,633,698.00 | 432,259,100.00 |
| 210602 | Тавилга | 9,899,900.00 | 2,562,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 580,699,009.45 | 239,227,478.78 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 59,435,580.00 | 61,175,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 204,560,122.36 | 188,581,787.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 152,239,198.00 | 106,297,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,140,000.00 | 1,140,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,500,000.00 | 6,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 756,684.36 | 935,437.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 341,000.00 | 363,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 23,759,840.00 | 37,187,150.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,350,800.00 | 6,350,800.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 18,472,600.00 | 29,808,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,808,900.00 | 12,260,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,808,900.00 | 12,260,750.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **45,339,500.00** | **45,476,600.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 45,339,500.00 | 45,476,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 45,339,500.00 | 45,476,600.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **820,769,072.65** | **282,279,365.39** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 820,769,072.65 | 282,279,365.39 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 17,621,487.93 | 838,390,562.58 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 838,390,560.58 | 1,120,669,927.97 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 4,317,355,948.94 | 2,793,736,487.58 | -9,240,226.19 | 7,101,852,210.33 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,317,355,948.94** | **2,793,736,487.58** | **-9,240,226.19** | **7,101,852,210.33** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -369,103,502.94 | -369,103,502.94 |
| **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,952,435,948.94** | **5,700,651,429.73** | **15,571,167,747.39** | **26,224,255,126.06** |
| **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **4,952,435,948.94** | **5,700,651,429.73** | **15,571,167,747.39** | **26,224,255,126.06** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 5,895,482.29 | 5,895,482.29 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,952,435,948.94** | **5,700,651,429.73** | **15,577,063,229.68** | **26,230,150,608.35** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -5,895,482.29 | 00.00 | -5,895,482.29 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 11,473,887,504.50 | 11,473,887,504.50 |
| **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,952,435,948.94** | **5,694,755,947.44** | **27,050,950,734.18** | **37,698,142,630.56** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 24,664,923,500.00 | 21,972,444,670.97 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 24,664,923,500.00 | 21,972,444,670.97 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 23,489,357,000.00 | 21,926,968,070.97 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 14,596,470,800.00 | 14,136,462,495.91 |
| 210101 | Үндсэн цалин | 7,685,647,000.00 | 8,069,538,856.98 |
| 210102 | Нэмэгдэл | 4,798,910,100.00 | 4,547,416,457.75 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 374,804,400.00 | 419,128,585.62 |
| 210104 | Урамшуулал | 1,737,109,300.00 | 1,100,378,595.56 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,775,367,500.00 | 1,745,717,058.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,234,642,500.00 | 1,250,583,701.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 135,181,300.00 | 122,612,015.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 67,590,600.00 | 68,861,269.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 67,590,600.00 | 57,139,036.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 270,362,500.00 | 246,521,036.01 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 338,452,000.00 | 329,543,558.69 |
| 210401 | Бичиг хэрэг | 25,000,000.00 | 22,611,880.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 158,000,000.00 | 131,393,187.69 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 35,452,000.00 | 33,412,231.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,000,000.00 | 8,528,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 110,000,000.00 | 133,597,860.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,996,419,800.00 | 4,779,177,841.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,632,880,800.00 | 4,424,451,490.80 |
| 210502 | Хоол, хүнс | 343,539,000.00 | 330,389,301.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 20,000,000.00 | 24,337,050.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,509,261,500.00 | 674,049,478.78 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 702,400,900.00 | 432,259,100.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 2,562,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,000,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 803,860,600.00 | 239,227,478.78 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 68,000,000.00 | 61,175,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 68,000,000.00 | 61,175,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 190,385,400.00 | 188,581,787.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 106,330,000.00 | 106,297,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,140,000.00 | 1,140,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,500,000.00 | 6,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,500,000.00 | 935,437.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1,300,000.00 | 363,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 33,143,000.00 | 37,187,150.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,350,800.00 | 6,350,800.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 30,121,600.00 | 29,808,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15000000.00 | 12260750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,000,000.00 | 12,260,750.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1175566500.00 | 45476600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,175,566,500.00 | 45,476,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 701,736,000.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 409,170,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 64,660,500.00 | 45,476,600.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 24,664,923,500.00 | 22,030,774,036.36 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,820,351,200.00 | 776,029,199.73 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 856,829,600.00 | 776,029,199.73 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,110,906,000.00 | 00.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 852,615,600.00 | 00.00 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 21,844,572,300.00 | 21,254,744,836.63 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 21,844,572,300.00 | 21,254,744,836.63 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 838,390,562.58 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 1,120,669,927.97 |

| | | | |
|---|---|---|---|
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 00.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 00.00 | 01.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 310.00 | 333.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 06.00 | 04.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 220.00 | 217.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 84.00 | 112.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,580,793,100.00 | 1,535,793,100.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,580,793,100.00 | 1,535,793,100.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,580,793,100.00 | 1,535,793,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,535,793,100.00 | 1,535,793,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 296,476,500.00 | 153,534,761.52 |
| 210302 | Түлш, халаалт | 810,894,600.00 | 1,047,544,375.48 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 428,422,000.00 | 334,713,963.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,580,793,100.00 | 1,535,793,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,580,793,100.00 | 1,535,793,100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,580,793,100.00 | 1,535,793,100.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нэгдсэн эмнэлэг нь иргэдэд эрүүл мэндийн лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг ба "Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн лавлагаа тусламж үйлчилгээг ээлтэй, чанартай, тасралтгүй тэгш хүртээмжтэй үзүүлж өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино" гэсэн зорилгын дор доорх зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хүн амын өвчлөл түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах
- Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эмнэл зүйн нотолгоонд суурилсан, дэвшилтэт технологийг тэргүүлэх чиглэл болгон үе шаттай нэвтрүүлэх замаар тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах
- Эрүүл мэндийн салбарын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, чадвар, хандлага бүхий эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг бэлтгэх, тасралтгүй суралцагч хамт болох
- Эмнэлгийн мэргэжилтэн болон олон нийтэд чиглэсэн ёс зүй, зан үйл, сэтгэл зүйг өөрчлөх өргөн хүрээтэй чадавх бэхжүүлэх болон мэдээлэл сургалт сурталчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэх
- Ажилтны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх
- Цахим эрүүл мэнд болон мэдээллийн технологийн нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглах
- Нэгдсэн эмнэлгийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгон сайн засаглал ил тод байдлыг дэмжих

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- Хөдөлмөр, Нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлс доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **10,887,920.3** мянган төгрөгөөр буюу 40.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 838,390.6 | 1,120,669.9 | 282,279.4 |
| Авлага | 2,131,882.4 | 2,327,998.9 | 196,116.5 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 1,365,609.7 | 1,212,873.2 | -152,736.5 |
| Үндсэн хөрөнгө | 22,780,901.4 | 33,343,162.4 | 10,562,260.9 |
| **Нийт хөрөнгө** | **27,116,784.1** | **38,004,704.4** | **10,887,920.3** |
| Өр төлбөр | 892,529.0 | 306,561.8 | -585,967.2 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 26,224,255.1 | 37,698,142.6 | 11,473,887.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **27,116,784.1** | **38,004,704.4** | **10,887,920.3** |

Бараа материалын дансны үлдэгдэл 1,212,873.2 мянган төгрөг болж 152,736.5 мянган төгрөгөөр буурсан нь эм боох материал, сэлбэг хэрэгсэл, аж ахуй, бусад хангамжийн материалын зарцуулалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 33,343,162.4 мянган төгрөг болж 10,562,260.9 мянган төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд авлагын үлдэгдэл 2,327,998.9 мянган төгрөг болж 196,116.5 мянган төгрөгөөр өсөхөд эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага нэмэгдсэн нь шууд нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 306,561.8 мянган төгрөг болж 585,967.2 мянган төгрөгөөр буурахад эмийн компаниудад төлөх өглөг буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 37,698,142.6 мянган төгрөг болж 11,473,887.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг 25,724,717.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогыг 382,397.0 төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 1,658,780.1 мянган төгрөгөөр бууруулж 24,448,328.0 мянган төгрөгөөр анх баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны анх батлагдсан төсвийг 176,595.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгол хийж 24,664,923.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 21,972,444.7 мянган төгрөг буюу 89.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2,692,478.8 мянган төгрөгөөр хэмнэж 1,120,669.9 төгрөгийн төрийн сангийн дансны үлдэгдэлтэй гарснаас шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71602-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 20,498,250.6 | 19,854,104.7 | 644,145.9 | 96.9% |
| 2 | 71602-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж | 64,660.5 | 45,476.6 | 19,183.9 | 70.3% |
| 3 | 71602-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 81639-Төр төлбөрийг нь хариуцах эмийн зардал | 55,844.9 | 55,844.9 | 0 | 100% |
| 4 | 71602-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 83603-Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан | 4,046,167.5 | 2,017,018.4 | 2,029,149.1 | 49.9% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэгдсэн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн төсвөөс 1,580,793.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,535,793.1 мянган төгрөгийг тогтмол зардалд зарцуулж, 45,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.
Хүснэгт 3. Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Программ хангамжтай холбоотой гарсан зардал | 31 187.2 | 1.Санхүүгийн программ лицензийн төлбөр<br>2.Даатгалын программын лицензийн төлбөр<br>3.Цаг бүртгэлийн программын төлбөр<br>4.Төрийн сангийн пос үйлчилгээний төлбөр<br>5.Pasc системийн төлбөр |
| 2 | Унаа хоолны зардлын гүйцэтгэл | 1.Хоол -454,881.0<br>2.Унаа-928.0 нийт 455,809.0 | 1. Нэгдсэн эмнэлгийн захирлын 2025 оны 01-р сарын 02-ны А/01 тоот тушаалын дагуу хоолны мөнгийг өдрийн 5000 төгрөгөөр тооцож олгож байгаа<br>2. Нэгдсэн эмнэлгийн захирлын 2025 оны 01-р сарын 02-ны А/01 тоот тушаал |

| | | | |
|---|---|---|---|
| | | | унааны мөнгийг өдрийн 1000 төгрөгөөр тооцож олгож байгаа |
| 3 | Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал | 12 260.75 | 1. Хоол боловсруулах эрхтний эмгэг хавдрын эрт илүүлэг баруун бүсийн ажлын байрны сургалт<br>2. VISION CARE төрийн бус байгууллагын Монгол улс дахь нүдний кэмп үйл ажиллагааны хөтөлбөрөөр 2025.05.30-06.06-ны хооронд АНУ болон БНСУ-ын хамтарсан 8 нарийн мэргэжлийн нүдний эмч, сувилагч нарын хамтарсан баг ажиллаж, 200 гаруй хүнд хийсэн сургалт үзлэг,оношилгоо хагалгаа хийсэн<br>3. Төвлөрлийг сааруулах үндэсний багийн үйл ажиллагааны сургалт<br>4. Алба хаагчдын сургалтын төлбөрт |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал | 0 | 2025 онд гадаад томилолт арга хэмжээнд зардал гараагүй болно . |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал | 0 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй болно. |
| 6 | Байгууллагын орон тоо | 413 хүн | 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01-р сарын 16-ны өдрийн 02 тоот тогтоолоор нэгдсэн эмнэлгийн орон тоог 444 хүнээр батлуулсан.<br>2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10-р сарын 22-ны өдрийн 21 тоот тогтоолоор нэгдсэн эмнэлгийн орон тоог 431.5 хүнээр батлуулсан. |
| 7 | Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл | 7,200.00 | Сама увс ХХК-тай 2025 оны 01-р сарын 02-ны өдрийн 25/01 тоот гэрээ<br>МБСТВ ХХК -тай 2025 оны 01-р сарын 02-ны өдрийн 05 тоот гэрээ |

#### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Нэгдсэн эмнэлэгт тайлант онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр“ төслийн хүрээнд 11,206,085.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

#### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд нийт 4,961,492.57 мянган төгрөгийн төсөвтэй хүнсний материалын 4 багц, шатах тослох материал, цэвэрлэгээний материал, эм, эмнэлгийн хэрэгслийн 34 багц, бичиг хэргийн материал, эмгэг судлалын лабораторийн багаж тоног төхөөрөмж, төрөх эмнэлгийн сантехникийн засварын ажил, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шатаар зөөвөрлөгч тоног төхөөрөмжийн нээлттэй тендер зохион байгуулсан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 21,953,702.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 219,537.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 175,629.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 24,800,563.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 248,005.6 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 198,404.5 мянган төгрөгөөр тогтоосон.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2025 оны Б/115, Б/221 дүгээр тушаалаар биеийн тамирын уралдаан, тэмцээний зардалд 8,460.0 мянга, Б/538 дугаар тушаалаар бэлэг дурсгалын зүйлд 1,110.0 мянган төгрөг зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,580,793.1 мянган төгрөгийн орлогын 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 165,027.9 мянган төгрөгийн зарлагын 11 гүйлгээ, 61,201.7 мянган төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,819,671.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 9,570.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,810,101.7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### 5.1 Албан шаардлага

Нэгдсэн эмнэлгийн даргын 2025 оны Б/115, Б/221 дүгээр тушаалаар биеийн тамирын уралдаан, тэмцээний зардалд 8,460.0 мянга, Б/538 дугаар тушаалаар бэлэг дурсгалын зүйлд 1,110.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 4.2.6 дахь заалтад "Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй", 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5 дахь заалтад "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8 дахь заалтад "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасныг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь:***

Зөрчлийг давтан гаргахгүй байхыг албан шаардлага болголоо.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***1.1. Илрүүлэлт:***

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 2-т "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, сувилагч, туслах сувилагч, асрагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч, сэтгэл засалчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно" гэж заасныг зөрчиж ахмадын эмчид 2,357.7 мянга, Ёс зүйн хорооны 2024 оны 5 дугаар тогтоолын 3.8-д "5 болон 7 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгоно" гэж заасныг зөрчиж байгууллагын ёс зүйн хорооны даргад 721.3 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон байна.

***1.2. Өгсөн зөвлөмж:***

Цаашид Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт, Ёс зүйн хорооны 2024 оны 5 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.

**2. *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

**2.1. *Илрүүлэлт:***

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,580,793.1 мянган төгрөгийн орлогын 12 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 165,027.9 мянган төгрөгийн зарлагын 11 гүйлгээ, 61,201.7 мянган төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

***2.2. Өгсөн зөвлөмж:***

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хууль, тогтоомж зөрчсөн | 2 | 12,649.0 | | | 1 | 9,570.0 | 1 | 3,079.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 2 | 12,649.0 | | | 1 | 9,570.0 | 1 | 3,079.0 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээлэл байршуулаагүй | 1 | 1,807,022.7 | | | | | 1 | 1,807,022.7 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 1,807,022.7 | | | | | 1 | 1,807,022.7 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | 1 | 1,807,022.7 | | | | | 1 | 1,807,022.7 |

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

9065555 1525010041

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР /Б.АВИРМЭД/

2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр